



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2025 оны 04 сарын 22-нд

Дугаар А135

Арвайхээр сум

Дэд хөтөлбөр батлах тухай

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, 19 дүгээр зүйл, 27 дугаар зүйлийн 27.5.1 дэх заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 15 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Суралцагчдын өргөтгөсөн чадавх, хөдөлмөрийн соёл, дадлага хичээлийн чанар үр дүнг сайжруулан түншлэлийн интеграцийг хөгжүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх "Суралцагчдыг хөдөлмөрт бэлтгэх дэд хөтөлбөр"-ийг нэгдүгээр хавсралт, "Элсэлт зохион байгуулах үйл ажиллагааны дэд хөтөлбөр"-ийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Сургалтын албаны менежер (С.Уртнасан)-т, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд жил тутам өөрийн үнэлгээ хийж, захирлын зөвлөлд танилцуулж ажиллахыг Чанарын баталгаажилт, дотоод хяналтын менежер(Б.Хуягмаа)-т тус тус үүрэг болгосугай.

3. Дэд хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн төлөвлөлтийг үнэн зөв төлөвлөж ажиллахыг Сургалтын албаны менежер (С.Уртнасан)-т, шаардагдах төсвийг төсвийн зохих зүйл ангиас зарцуулахыг Ерөнхий нягтлан болоч(С.Хандсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАЛ



С.САНЧИР

## ЭЛСЭЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өрсөлдөх чадвартай, мэргэжлийн өндөр ёс зүй, үр чадвар бүхий үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх эрхэм зорилгынхоо хүрээнд ажил мэргэжлийн талаарх мэдээ, мэдээллийг хүргэх, өөрийн авьяас чадвар сонирхолд тулгуурласан суралцагч, иргэдэд элсэлтийн ажлыг зохион байгуулахад энэхүү хөтөлбөр чиглэнэ.

Элсэлт хөтөлбөр нь "Монгол Улсын Үндсэн хууль", "Мэргэжлийн болон Техникийн боловсрол сургалтын тухай хууль", "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль", "Боловсролын тухай хууль", "Алсын хараа -2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, "Өвөрхангай аймгийн засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд тус хөтөлбөр нь Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" болон 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-д дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг болно.

Энэхүү хөтөлбөрт төр-хувийн хэвшил-мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын оновчтой хамтын ажиллагааг төлөвшүүлэх, суралцагчдын өөрийн авьяас чадвар, сонирхол, хэрэгцээ, дотоод нөөц боломж дээр тулгуурласан бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн элсэлтийг зохион байгуулах асуудлыг тусгана.

### Хоёр. Зорилго

Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын захиалга, элсэгчдийн хүсэл сонирхолд тулгуурлан элсэлтийн үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй зохион байгуулах, **мэргэжлийн болон техникийн боловсролын талаарх олон нийтийн ойлголт, хандлага, үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.**

### Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1 Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээний сан бүрдүүлнэ.

3.2 Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын бодлого чиглэлийг сурагч, иргэд, олон нийтэд сурталчилна.

3.3. Төр, төрийн бус, аж ахуй нэгж байгууллагын түншлэлийн интеграцийг хөгжүүлнэ.

## **Дөрөв. Хөтөлбөрийн зарчим**

4.1. Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон Техникийн боловсрол сургалтын тухай хууль болон холбогдох бусад бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нийцсэн байх

4.2. Хөтөлбөрийг суралцагч, иргэдийн хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, тэдний өөрсдийн сонирхолд нийцүүлсэн байх

4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй, уян хатан байх

4.4. Нийгмийн баталгааг хангахад чиглэсэн байх

## **Тав. Хөтөлбөрийн хугацаа**

5.1. 2025-2029 онуудад хэрэгжинэ.

## **Зургаа. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

6.1. Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчдын захиалгад нийцүүлэн сурагчдын авьяас сонирхол, хэрэгцээнд тулгуурлан элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах зорилтын хүрээнд:

6.1.1. Бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа гаргах

6.1.2 Ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг судлан эрэлттэй мэргэжлийн жагсаалт гаргах

6.1.3. Элсэлтийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Захирлын тушаалаар баталгаажуулан төлөвлөгөө гарган бүс орон нутгийн болон ажил олгогчдын хэрэгцээний судалгааны үр дүнгээр элсэлтийн хяналтын тоог боловсруулан сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлах, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллах

6.2 Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын бодлого чиглэлийг сурагч, иргэд, олон нийтэд сурталчилах зорилтын хүрээнд:

6.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 9 дугаар ангийн сурагчдын сонирхол, хэрэгцээ, дотоод нөөц боломж, мэргэжил сонголтод хамтран жил бүр "Манай сургуульд тавтай морил" арга хэмжээг зохион байгуулах

6.2.2. Өвөрхангай аймгийн 19 сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн суралцагчид, иргэдэд элсэлтийг сурталчлах, мэдээлэл хүргэх, бүртгэл хийх

6.2.3 Сургуулийн page хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэргэжлүүдийн танилцуулга бүхий постер, контентийг хүргэх

6.2.4 Арвайхээр сумын 13 багийн хөдөлмөрийн насны ажилгүй иргэдэд "Мэргэжлийн боловсрол сургалтын мэдээлэллийн яармаг" арга хэмжээг зохион байгуулах

6.3. Түншлэлийн интерацийг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах зорилтын хүрээнд:

6.3.1 Боловсролын байгууллагууд, ажил олгогчид, бодлого боловсруулагчид, хөгжлийн түншүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх Түншлэлийн зөвөлгөөнийг зохион байгуулах, үр дүнг тооцох

6.3.2 Сурагчдад мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого хэрэгжилтийг сурталчлах, карьерийн зөвөлгөө өгөх, өөрийн сонирхол, үр чадварт нийцсэн мэргэжил сонгоход дэмжлэг үзүүлэх тестэнд хамруулан

ерөнхий боловсролын сурагчидын ажил мэргэжилийн чиг баримжаа олгох интерактив ажлыг хөгжүүлэн ажиллах,  
6.3.3 Мэргэжлийн холбоодтой хамтран суралцагчдад сургалт зохион байгуулах



### **Долоо. Дэд хөтөлбөрийн хугацаа**

7.1. Хөтөлбөрийг 2025-2029 оныг дуустал хэрэгжүүлнэ.

### **Найм. Дэд хөтөлбөрийн санхүүжилт**

8.1. Дэд хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

8.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

8.1.2. Бусад эх үүсвэр

### **Ес. Дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт**

9.1. Сургалтын алба нь дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хяналт үнэлгээ хийх, зөвлөн туслах үүргийг хүлээнэ. Үүнд:

9.1.1. Дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг хичээлийн жилээр төлөвлөн нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч нар, нийгмийн ажилтан, мэргэжлийн багш нартай хамтран боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана.

9.1.2. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас жилд 1 удаа Чанарын баталгаажилт, дотоод хяналтын алба хийнэ.

9.1.3. Үнэлгээний үр дүнг сургуулийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, дүгнэлт гаргана.

**Арав. Дэд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин**



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				Хариуцах эзэн Хамтрах эзэн
			2025он	2026он	2027он	2028он	
<p align="center"><b>3.1 Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчдын хэрэгцээний сан бүрдүүлнэ.</b></p>							
1.	Бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа гаргах	Тоо:Тухайн жилийн хяналтын тоо, хөтөлбөрийн тоо Чанар: Тухайн жилийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааг бүс орон нутгийн хэмжээнд гаргаж ажилласан байна.	100%	100%	100%	100%	Сургалтын алба Элсэлт зохион байгуулах ажлын хэсэг
2.	Ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагыг судлан эрэлттэй мэргэжлийн жагсаалт гаргах	Тоо: 1 Чанар: Ажил олгогчдын хэрэгцээ шаардлагын судалгааг жилд 1 удаа авч эрэлттэй мэргэжлийн жагсаалт гарган ажилласан байна.	100%	100%	100%	100%	Сургалтын алба Элсэлт зохион байгуулах ажлын хэсэг



3	Элсэлтийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг захирлын тушаалаар баталгаажуулан төлөвлөгөө гарган бүс орон нутгийн болон ажил олгогчдын хэрэгцээний судлагааны үр дүнгээр элсэлтийн хяналтын тоог боловсруулан сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлах, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллах	Тоо: 2 Чанар: Бүс орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүн, ажил олгогчдын хэрэгцээ шаардлагын судалгааны дүнг нэгтгэн сургуулийн элсэлт авах мэргэжлүүдийг тодорхойлж элсэлтийн хяналтын тоог боловсруулан сургуулийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажилласан байна.	100%	100%	100%	100%	Элсэлт зохион байгуулах ажлын хэсэг
---	---	---	------	------	------	------	-------------------------------------



**3.2 Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын бодлого чиглэлийг сурагч, иргэд, олон нийтэд сурталчилах**

1	Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 9 дугаар ангийн суралцагчдын сонирхол, хэрэгцээ, дотоод нөөц боломж, мэргэжил сонголтод хамтран жил бүр "Манай сургуульд тавтай морил" арга хэмжээг зохион байгуулах	- Тоо: 4 удаагийн үйл ажиллагаа Хамрагдах суралцагчдын тоо 600 Чанар: - Арвайхээр сумын ерөнхий боловсролын I,II,IV,V сургуулийн 9 ангийн суралцагчдад "Манай сургуульд тавтай морил" арга хэмжээг зохион байгуулж мэргэжил сонголт болон элсэлтийг суртчилан ажиллана.	100%	100%	100%	100%	Элсэлтийг зохион байгуулах ажлын хэсэг
2	Өвөрхангай аймгийн 19 сумын ерөнхий боловсролын сургуулийн 9 ангийн суралцагчид,	- Тоо : 23 сургуулийн 9-р анги төгсөх 1500 суралцагчдад мэдээлэл хүргэх Батлагдсан мэргэжлийн квотын дагуу элсэлтийн	100%	100%	100%	100%	



	иргэдэд элсэлтийг сурталчлах, мэдээлэл хүргэх, бүртгэл хийх	ажлын хэсгийг байгуулан чиглэлийн хуваарийг гаргаж, Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургууль, 19-н сумдад ажиллаж элсэлтийн ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байна.					Элсэлтийг зохион байгуулах ажлын хэсэг
3	Сургуулийн page хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэргэжлүүдийн танилцуулга бүхий постер, богино хэмжээний видеог хүргэж түгээх	-Тоо: Постер 3 ш, Видео 1 ш, брошур 2000ш Элсэлт авах мэргэжлүүдийн онцлогийг харуулан таниулсан богино хэмжээний видео болон постер, 2000 ш брошурийг хэвлэн хүргэсэн байна.	100%	100%	100%	100%	Элсэлтийг зохион байгуулах ажлын хэсэг
4	Арвайхээр сумын 13 багийн хөдөлмөрийн насны ажилгүй иргэдэд "Мэргэжлийн	- Тоо :1 - Арвайхээр сумын ЗДТГ тай хамтран - Арвайхээр сумын 13 багийн хөдөлмөрийн насны ажилгүй иргэдэд "Мэргэжлийн	100%	100%	100%	100%	Арвайхээр сумын ЗДТГ, Сургалтын алба



	боловсрол сургалтын мэдээлэллийн яармаг" арга хэмжээг зохион байгуулах	боловсрол сургалтын мэдээлэллийн яармаг" арга хэмжээг зохион байгуулж ажиллана.					
<b>3.3 Гурав. Түншлэлийн интеграцийг сайжруулах олон талт арга хэмжээг зохион байгуулах</b>							
1	Түншлэлийн зөвлөгөөнийг зохион байгуулах	-Тоо: Зөвлөгөөн 1 Түншлэлийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгуулан ажилласан байна.	100%	100%	100%	100%	Зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсэг
2	Сурагчдад мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого, хэрэгжилтийг сурталчлах, карьерийн зөвлөгөө өгөх, өөрийн сонирхол, үр чадварт нийцсэн мэргэжил	- Тоо: Сургууль дадлагын газартай танилцуулах арга хэмжээ -5 - Мэргэжлийн болон техникийн боловсролын суралцагчдад сургалт 1 Сурагчдад мэргэжлийн болон техникийн боловсролын бодлого, хэрэгжилтийг сурталчлах, карьерийн	100%	100%	100%	100%	Аймгийн ажил мэргэжлийн холбооны салбар зөвлөл, Сургалтын алба



	сонгоход дэмжлэг үзүүлэх тестэнд хамруулан ерөнхий боловсролын сурагчидын ажил мэргэжилчиг баримжаа олгох интерактив ажлыг хөгжүүлэн ажиллах,	зөвөлгөө өгөх, өөрийн сонирхол, ур чадварт нийцсэн мэргэжил сонгоход дэмжлэг үзүүлэх тестэнд хамруулан ерөнхий боловсролын сурагчидын ажил мэргэжилчиг баримжаа олгох интерактив ажлыг хөгжүүлэн ажилласан байна.					
3	6.3.3 Мэргэжлийн холбоодтой хамтран суралцагчдад сургалт зохион байгуулах	- Тоо 4 Мэргэжлийн холбоодтой хамтран суралцагчдад Миний мэргэжил миний бахархал сургалт арга хэмжээг зохион байгуулан ажилласан байна.	100%	100%	100%	100%	Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн дэргэдэх мэргэжлийн холбоод, Сургалтын алба